



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 5/286

Улаанбаатар хот

Элсэлтийн шалгалтын журам батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг, Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам”-ыг нэгдүгээр, “ХСИС-ийн 2014-2015 оны хичээлийн жилийн мэргэжлийн боловсрол олгох болон мэргэжлийн сургалтын элсэлтийн журам”-ыг хоёрдугаар, “ХСИС-ийн 2014-2015 оны бакалаврын зэрэг олгох сургалтын элсэлтийн журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан журмуудыг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчилах, мэдээлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Сургалт эрхэлсэн дэд захирал бөгөөд Сургалтын бодлого, зохицуулалтын газрын дарга /цагдаагийн хурандаа Г.Гантөмөр/-д үүрэг болгосугай.


3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Захиргааны удирдлагын газрын дарга /цагдаагийн хурандаа Д.Амарсайхан/-д даалгасугай.

ЗАХИРАЛ, ПРОФЕССОР,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Р.ЧИНГИС

ХУУЛБАР ҮНЭН  
Захиргааны удирдлагын газрын дарга,  
цагдаагийн хурандаа

Д.Амарсайхан



000724

**ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Хууль сахиулахын их сургуулийн /цаашид ХСИС гэх/ боловсролын зэрэг олгох бүх төвшний сургалтад суралцагч элсүүлэхтэй холбогдон үүсэх нийтлэг харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам /цаашид элсэлтийн журам гэх/ нь Монгол Улсын "Боловсролын тухай хууль", "Дээд боловсролын тухай хууль", Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", "ХСИС-ийн дотоод журам", захиалагч агентлагуудын хүний нөөцийг бэлтгэх, сонгон шалгаруулахтай холбогдох харилцааг зохицуулсан бусад хууль, эрх зүйн актуудад нийцсэн байна.
- 1.3. Энэхүү нийтлэг журмаар тогтоосон хэм хэмжээнд үндэслэн тухайн хичээлийн жилд мөрдөх мэргэжлийн боловсрол, сургалт, бакалавр, Удирдлагын сургууль, магистр, докторын зэрэг олгох сургалтын төвшин бүрийн элсэлтийн шалгалт зохион байгуулах журмыг элсэлтийн шалгалтын төв комисс /цаашид төв комисс гэх/-ын хуралдаанаар хэлэлцүүлэн ХСИС-ийн захирлаар батлуулж, мөрдөнө.
- 1.4. ХСИС-ийн боловсролын зэрэг олгох тухайн төвшний сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журмаар элсүүлэн суралцуулах мэргэжлийн чиглэл, шалгалтын төрөл, агуулга, дэг, суурь ба хавсралт шалгалтын босго оноог тогтоож, чанарын оноог бодох аргачлал, элсэлт зохион байгуулах хугацаа зэргийг заана.
- 1.5. Хууль сахиулахын их сургуулийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно.  
"Бүртгэлийн сан" гэж элсэлтийн цахим бүртгэлийн мэдээллийг;  
"Элсэхийг хүсэгч" гэж ХСИС-ийн элсэлтийн цахим бүртгэлийн санд бүртгүүлсэн иргэнийг;  
"Элсэгч" гэж зохих шаардлага, шалгуурыг хангаж, элсэлтийн хяналтын тоонд багтсан элсэхийг хүсэгчийг;  
"Алба хаагч" гэж хууль сахиулах албанд ажиллаж буй иргэнийг;  
"Элсэлтийн шалгалтын комисс" гэж элсэлтийн шалгалтыг зохион байгуулахаар томилогдсон бүрэлдэхүүнийг;  
"Нэмэлт шалгалт" гэж сургууль өөрийн онцлогт тохируулан авч буй бие бялдар, сэтгэл зүйн сорил, ярилцлагыг;  
"Шалгалтын хуудас" гэж элсэхийг хүсэгчийн шалгалтын оноо, үнэлгээний мэдээлэл бүхий хуудсыг;  
"Мэргэжлийн боловсрол" гэж тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж, зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг;  
"Мэргэжлийн сургалт" гэж тодорхой ажил хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх үйл ажиллагааг хэлнэ гэж тус тус ойлгоно.
- 1.6. Элсэлтийн шалгалтын комисс нь /цаашид элсэлтийн комисс гэх/ элсэлтийн шалгалтыг хууль ёсны, шударга, нээлттэй байх, мэдээллийн хүртээмжтэй, шуурхай байдлыг хангах, зарчмуудыг удирдлага болгон хараат бусаар бие даан зохион байгуулна.
- 1.7. ХСИС-д гадаадын иргэнийг элсүүлэх асуудлыг холбогдох журмаар зохицуулна.
- 1.8. Элсэлтийн шалгалтын үйл ажиллагааны зардлын тооцоонд үндэслэн элсэхийг хүсэгчээс хураах хураамжийн хэмжээг элсэлтийн төв комисс шийдвэрлэнэ.
- 1.9. Энэхүү журам болон элсэлтийн шалгалттай холбогдох мэдээллийг ХСИС-ийн "[www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn)" болон захиалагч агентлаг, байгууллагуудын цахим хуудсанд байршуулна.

**ХОЁР. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН КОМИСС, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ**

- 2.1. Хууль сахиулахын их сургуулийн элсэлтийн шалгалтыг төв ба салбар комисс зохион байгуулна.

- 2.1.1. Элсэлтийн төв комиссыг Хууль сахиулахын их сургуулийн захирлын тушаалаар томилох ба дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэй байна.
- 2.1.2. Элсэлтийн шалгалтын салбар комисс /цаашид салбар комисс гэх/ нь боловсролын зэрэг олгох сургалтын төвшин бүрээр байгуулагдах ба бүрэлдэхүүнийг төв комиссын санал болгосноор ХСИС-ийн захирал батална.
- 2.2. Төв ба салбар комиссын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.
- 2.3. Төв комиссын чиг үүрэг:
  - 2.3.1. Тухайн хичээлийн жилийн төв комиссын ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталж, салбар комиссын бүрэлдэхүүний саналыг ХСИС-ийн захиралд хүргүүлэх;
  - 2.3.2. Тухайн хичээлийн жилийн боловсролын зэрэг олгох сургалтын төвшин бүрийн элсэлтийн шалгалт зохион байгуулах журмын төслийг хэлэлцэж, батлуулахаар ХСИС-ийн захиралд хүргүүлэх;
  - 2.3.3. Элсэлтийн журамтай холбогдон гарсан санал, гомдлыг шийдвэрлэх, боловсронгуй болгох саналыг ХСИС-ийн захиралд танилцуулах;
  - 2.3.4. Элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдон гарах зардлын тооцоог гаргаж, элсэхийг хүсэгчээс хураах хураамжийн хэмжээг тогтоох;
- 2.4. Элсэлтийн төв комиссын даргын бүрэн эрх:
  - 2.4.1. Салбар комиссын ажлын төлөвлөгөөг батлан, мэргэжлийн хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулах;
  - 2.4.2. Элсэлтийн комиссын хуралдааныг удирдах;
  - 2.4.3. Элсэлтийн комиссыг нэгдсэн удирдлагаар хангах;
  - 2.4.4. Элсэлтийн шалгалттай холбоотой иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;
  - 2.4.5. Элсэлтийн шалгалтын явцад комиссын гишүүдийн гаргасан зөрчлийг шалгах, өөрчлөн томилуулах саналыг ХСИС-ийн захиралд танилцуулж, шийдвэрлүүлэх;
  - 2.4.6. Элсэлтийн шалгалтын явц, үр дүнгийн тайланг ХЗЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад тайлагнах;
  - 2.4.7. Элсэхийг хүсэгчид хөнгөлөлт үзүүлэх хүсэлттэй танилцаж, шийдвэрлэх;
  - 2.4.8. Элсэлтийн шалгалттай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх;
- 2.5. Салбар комисс нь мэргэжлийн боловсрол олгох, бакалавр, Удирдлагын сургууль, магистр, докторын зэрэг эзэмшүүлэх сургалтын чиглэлээр байгуулагдаж, дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 2.5.1. Элсэлтийн шалгалтын талаар олон нийтэд мэдээлэх, сурталчлах;
  - 2.5.2. Батлагдсан төлөвлөгөөний дагуу элсэлтийн шалгалтыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;
  - 2.5.3. Элсэхийг хүсэгчдийг судлах судалгааны чиглэл, шалгуур, арга хэлбэрийг захиалагч агентлагуудын холбогдох нэгжтэй зөвшилцөн тодорхойлж, зохион байгуулах;
  - 2.5.4. Элсэлтийн шалгалтын дүнг нэгтгэж, төв комисст танилцуулж, шийдвэрлүүлэх;
  - 2.5.5. Элсэлтийн шалгалтын журмыг боловсронгуй болгох санал гаргах;
  - 2.5.6. Элсэлтийн шалгалттай холбоотой мэдээ, тайланг тогтоосон загварын дагуу гаргаж, төв комиссын нарийн бичгийн даргад хүргүүлэх зэрэг болно.
- 2.6. Элсэлтийн комиссын нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 2.6.1. Элсэлтийн шалгалтын бэлтгэл ажлыг хангах;
  - 2.6.2. Шалгалтыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулах, гүйцэтгэлийг хангах;
  - 2.6.3. Элсэлтийн шалгалттай холбоотой асуудлаар шалгалтын комиссын дарга, гишүүдийг мэдээллээр хангах;
  - 2.6.4. Элсэлттэй холбогдсон хууль тогтоомж, журам, үйл ажиллагааны бусад мэдээллийг иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулах;
  - 2.6.5. Элсэлтийн шалгалтанд орох иргэн, албан хаагчдын материалыг хүлээн авах, бүртгэх, хянах, хадгалалт хамгаалалтыг хариуцах;
  - 2.6.6. "Сэтгэл зүйн сорил"-ын нэмэлт шалгалтын асуулт, тест, бусад холбогдох материалыг бэлтгэж, нууцлалыг хангах ажлыг зохион байгуулах;
  - 2.6.7. Шалгалтын дүнг нэгтгэн гаргаж, элсэлтийн комиссын болон орлогч даргад танилцуулах;
  - 2.6.8. Элсэлтийн шалгалтын сэдэв, агуулгыг чанаржуулах, оновчтой болгох, болон шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулах, хуралдаанаар хэлэлцүүлэх;
  - 2.6.9. Комиссын хуралдааны бэлтгэл ажлыг хангах, шийдвэрлүүлэх асуудлын талаар танилцуулга бэлтгэх;

- 2.1.1. Элсэлтийн төв комиссыг Хууль сахиулахын их сургуулийн захирлын тушаалаар томилох ба дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэй байна.
- 2.1.2. Элсэлтийн шалгалтын салбар комисс /цаашид салбар комисс гэх/ нь боловсролын зэрэг олгох сургалтын төвшин бүрээр байгуулагдах ба бүрэлдэхүүнийг төв комиссын санал болгосноор ХСИС-ийн захирал батална.
- 2.2. Төв ба салбар комиссын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.
- 2.3. Төв комиссын чиг үүрэг:
  - 2.3.1. Тухайн хичээлийн жилийн төв комиссын ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталж, салбар комиссын бүрэлдэхүүний саналыг ХСИС-ийн захиралд хүргүүлэх;
  - 2.3.2. Тухайн хичээлийн жилийн боловсролын зэрэг олгох сургалтын төвшин бүрийн элсэлтийн шалгалт зохион байгуулах журмын төслийг хэлэлцэж, батлуулахаар ХСИС-ийн захиралд хүргүүлэх;
  - 2.3.3. Элсэлтийн журамтай холбогдон гарсан санал, гомдлыг шийдвэрлэх, боловсронгуй болгох саналыг ХСИС-ийн захиралд танилцуулах;
  - 2.3.4. Элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдон гарах зардлын тооцоог гаргаж, элсэхийг хүсэгчээс хураах хураамжийн хэмжээг тогтоох;
- 2.4. Элсэлтийн төв комиссын даргын бүрэн эрх:
  - 2.4.1. Салбар комиссын ажлын төлөвлөгөөг батлан, мэргэжлийн хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулах;
  - 2.4.2. Элсэлтийн комиссын хуралдааныг удирдах;
  - 2.4.3. Элсэлтийн комиссыг нэгдсэн удирдлагаар хангах;
  - 2.4.4. Элсэлтийн шалгалттай холбоотой иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;
  - 2.4.5. Элсэлтийн шалгалтын явцад комиссын гишүүдийн гаргасан зөрчлийг шалгах, өөрчлөн томилуулах саналыг ХСИС-ийн захиралд танилцуулж, шийдвэрлүүлэх;
  - 2.4.6. Элсэлтийн шалгалтын явц, үр дүнгийн тайланг ХЗЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад тайлагнах;
  - 2.4.7. Элсэхийг хүсэгчид хөнгөлөлт үзүүлэх хүсэлттэй танилцаж, шийдвэрлэх;
  - 2.4.8. Элсэлтийн шалгалттай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх;
- 2.5. Салбар комисс нь мэргэжлийн боловсрол олгох, бакалавр, Удирдлагын сургууль, магистр, докторын зэрэг эзэмшүүлэх сургалтын чиглэлээр байгуулагдаж, дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 2.5.1. Элсэлтийн шалгалтын талаар олон нийтэд мэдээлэх, сурталчлах;
  - 2.5.2. Батлагдсан төлөвлөгөөний дагуу элсэлтийн шалгалтыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;
  - 2.5.3. Элсэхийг хүсэгчдийг судлах судалгааны чиглэл, шалгуур, арга хэлбэрийг захиалагч агентлагуудын холбогдох нэгжтэй зөвшилцөн тодорхойлж, зохион байгуулах;
  - 2.5.4. Элсэлтийн шалгалтын дүнг нэгтгэж, төв комисст танилцуулж, шийдвэрлүүлэх;
  - 2.5.5. Элсэлтийн шалгалтын журмыг боловсронгуй болгох санал гаргах;
  - 2.5.6. Элсэлтийн шалгалттай холбоотой мэдээ, тайланг тогтоосон загварын дагуу гаргаж, төв комиссын нарийн бичгийн даргад хүргүүлэх зэрэг болно.
- 2.6. Элсэлтийн комиссын нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 2.6.1. Элсэлтийн шалгалтын бэлтгэл ажлыг хангах;
  - 2.6.2. Шалгалтыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулах, гүйцэтгэлийг хангах;
  - 2.6.3. Элсэлтийн шалгалттай холбоотой асуудлаар шалгалтын комиссын дарга, гишүүдийг мэдээллээр хангах;
  - 2.6.4. Элсэлттэй холбогдсон хууль тогтоомж, журам, үйл ажиллагааны бусад мэдээллийг иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулах;
  - 2.6.5. Элсэлтийн шалгалтанд орох иргэн, албан хаагчдын материалыг хүлээн авах, бүртгэх, хянах, хадгалалт хамгаалалтыг хариуцах;
  - 2.6.6. "Сэтгэл зүйн сорил"-ын нэмэлт шалгалтын асуулт, тест, бусад холбогдох материалыг бэлтгэж, нууцлалыг хангах ажлыг зохион байгуулах;
  - 2.6.7. Шалгалтын дүнг нэгтгэн гаргаж, элсэлтийн комиссын болон орлогч даргад танилцуулах;
  - 2.6.8. Элсэлтийн шалгалтын сэдэв, агуулгыг чанаржуулах, оновчтой болгох, болон шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулах, хуралдаанаар хэлэлцүүлэх;
  - 2.6.9. Комиссын хуралдааны бэлтгэл ажлыг хангах, шийдвэрлүүлэх асуудлын талаар танилцуулга бэлтгэх;

- 2.6.10. Хуралдааны тэмдэглэлийг хөтөлж, хурлаас гарсан шийдвэрийг зохих журмын дагуу албажуулах ажлыг зохион байгуулах.
- 2.7. Элсэлтийн шалгалтад эцэг, эхийн төлөөллийг оролцуулан хөндлөнгийн хяналт хийлгэж болно.

#### **ГУРАВ. СУРАЛЦУУЛАХ МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ, СУРГАЛТЫН ХЭЛБЭР**

- 3.1. ХСИС нь хууль сахиулагчдыг Хөдөлмөрийн яамнаас олгосон "Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл"-ийн хүрээнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалт, БШУЯ-наас олгосон "Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл"-ийн хүрээнд бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтуудад тус тус шатлан мэргэшүүлж бэлтгэнэ.
- 3.2. Хууль зүйн яамны харьяа захиалагч агентлаг, байгууллагууд нь тухайн жилд элсүүлэх мэргэжлийн чиглэл, боловсон хүчний захиалгыг жил бүрийн 02 сарын 01-ний дотор ХСИС-д ирүүлнэ.
- 3.3. ХСИС захиалгат боловсон хүчнийг бэлтгэх эрэлт, хэрэгцээ, шаардлага, боломж, нөхцөлийг судлан Хууль зүйн яамтай зөвшилцөн элсэгчдийн хяналтын тоог тогтоон, мэргэжлийн боловсролын сургалтад элсэгчдийн хяналтын тоог Хөдөлмөрийн яамаар, бакалаврын зэрэг олгох, сургалтад элсэгчдийн хяналтын тоог БШУЯ-аар тус тус батлуулна.
- 3.3. Магистр, докторын сургалтад элсүүлэх мэргэжлийн чиглэл, хяналтын тоог мэргэжлийн профессорын багуудын саналыг үндэслэн ХСИС-ийн захирал батална.
- 3.4. Элсэлтийн комисс нь Хөдөлмөрийн яамнаас баталсан хяналтын тооны хүрээнд мэргэжлийн боловсролын, БШУЯ-наас баталсан хяналтын тооны хүрээнд бакалаврын боловсролын, ХСИС-ийн захирлын тушаалаар баталсан хяналтын тооны хүрээнд магистр, докторын зэрэг олгох сургалтын элсэлтийн шалгалтыг тус тус зохион байгуулна.
- 3.5. ХСИС нь элсэлтийн шалгалтыг улс, аймаг, хот, бүсийн хэмжээнд зохион байгуулж болно.
- 3.6. ХСИС нь боловсролын зэрэг олгох бүх төвшний сургалтыг өдөр, эчнээ, экстернат, зайн хэлбэрүүдээр зохион байгуулж болно.
- 3.7. Элсэхийг хүсэгч суралцах мэргэжлийн чиглэл, боловсролын төвшин, сургалтын хэлбэрээ сонгож, элсэлтийн шалгалтад орно.

#### **ДӨРӨВ. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧИД ТАВИХ ШААРДЛАГА**

- 4.1. ХСИС-ийн боловсролын зэрэг олгох бүх төвшний сургалтад элсэхийг хүсэгчид тавих шаардлага нь эзэмшсэн боловсрол, суралцах сургалтын хэлбэрээс хамааран ялгамжтай байна.
- 4.1.1. Мэргэжлийн боловсролын сургалтад элсэхийг хүсэгч нь бүрэн дунд болон дээд боловсрол эзэмшсэн иргэн байна.
- 4.1.2. Бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүсэгч нь ХСИС-д мэргэжлийн боловсрол эзэмшсэн сонсогч болон мэргэжлийн боловсролтой болон дээд боловсролтой алба хаагч байна.
- 4.1.3. Бакалаврын зэрэг олгох 5.5 жилийн эчнээ сургалтад элсэгч нь бүрэн болон тусгай дунд боловсролтой алба хаагч байна.
- 4.1.4. Бакалаврын зэрэг олгох 3 жилийн эчнээ сургалтад элсэхийг хүсэгч нь дээд боловсролтой алба хаагч байна.
- 4.1.5. Удирдлагын сургуульд элсэхийг хүсэгч нь захиалагч байгууллагын үндсэн чиглэлээр мэргэжил эзэмшсэн, тодорхой албан тушаалын нөөцөд бүртгэгдсэн алба хаагч байна.
- 4.1.6. Магистр, докторын зэрэг олгох сургалтад элсэхийг хүсэгч нь хууль сахиулах албанд болон бусад байгууллагад ажиллаж буй тухайн мэргэжлээр бакалавр, магистрын зэрэг эзэмшсэн алба хаагч байна.
- 4.2. ХСИС-д элсэхийг хүсэгчид тавих нийтлэг шаардлага:
- 4.2.1. Нүүрний хэлбэр төрх зөв, ил харагдах 20X05 мм-ээс том сорви, шивээсгүй, бие эрхтний гэмтэл согоггүй, эрүүл байх;
- 4.2.2. Биеийн өндөр: Эрэгтэй 165 см ба түүнээс дээш, эмэгтэй 160 см ба түүнээс дээш байх;
- 4.2.3. Боловсролын зэрэг олгох тухайн сургалтын төвшинд тавигдах насны хязгаарт нийцсэн байх;
- 4.2.3.1. Мэргэжлийн боловсрол, бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүсэгч эрэгтэй 17-оос 25 хүртэл, эмэгтэй 17-20 хүртэл настай байх;

- 4.2.3.2. Бакалаврын төвшний эчнээ болон өдрийн сургалтад элсэхийг хүсэгч алба хаагч нь тухайн агентлагуудын хүний нөөцийг бэлтгэх, сонгон шалгаруулахтай холбогдох харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн актуудаар тогтоосон насны хязгаарт нийцсэн байх;
- 4.2.3.3. Удирдлагын сургуульд элсэхийг хүссэн алба хаагч нь захиалагч байгууллагын тодорхой албан тушаалд тавигдах насны хязгаарт нийцсэн байх;
- 4.3. ХСИС-д элсэхийг хүсэгчид тавих тусгай шаардлага:
- 4.3.1. Мэргэжлийн боловсролын сургалтад элсэхийг хүсэгчид тавих тусгай шаардлагыг “ХСИС-ийн мэргэжлийн боловсрол олгох болон мэргэжлийн сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журам”-аар;
- 4.3.2. Бакалаврын зэрэг олгох сургалтад элсэхийг хүсэгчид тавих тусгай шаардлагыг “ХСИС-ийн бакалаврын сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журам”-аар;
- 4.3.3. Удирдлагын сургуулийн магистрын төвшний мэргэжил олгох сургалтад элсэхийг хүсэгчид тавих тусгай шаардлагыг Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, Хил хамгаалах, Онцгой байдлын болон хууль сахиулах бусад байгууллагын удирдах ажилтанд тавих албаны шаардлагыг үндэслэн ХСИС-ийн “Удирдлагын сургуульд элсүүлэн суралцуулах тухай журам”-аар;
- 4.3.4. Магистр, докторын зэрэг олгох өдөр, эчнээ, экстернат хэлбэрийн сургалтад элсэхийг хүсэгчид тавих тусгай шаардлагыг ХСИС-ийн “Магистр, докторын сургалтын журам”-аар;
- 4.3.5. Агентлаг, байгууллагуудын захиалгат богино хугацааны мэргэжлийн сургалтад элсэхийг хүсэгчид тавих тусгай шаардлагыг агентлагуудын хүний нөөцийг бэлтгэх, сонгон шалгаруулахтай холбогдох харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн актууд болон ХСИС-ийн “Мэргэжлийн боловсрол олгох болон мэргэжлийн сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журам”-аар тус тус тогтооно.

#### **ТАВ. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧДИЙГ БҮРТГЭХ**

- 5.1. Сургалтын бүх төвшний элсэлтийн бүртгэлийг цахим хэлбэрээр тухайн сургалтын элсэлтийн журмаар заасан хугацаанд явуулна.
- 5.2. Элсэхийг хүсэгч тухайн хичээлийн жилд зөвхөн нэг мэргэжлээр, суралцах боловсролын төвшин, сургалтын хэлбэрээ сонгож бүртгүүлнэ.
- 5.3. Бүртгүүлэхийн өмнө энэ журам болон элсэхээр сонгосон боловсролын төвшний тухайн хичээлийн жилийн “Элсэлтийн шалгалт зохион байгуулах журам”, бусад нэмэлт мэдээллүүдтэй танилцсан байна.
- 5.4. Бүртгүүлсэн элсэхийг хүсэгчдэд хувийн нууц код олгож, цахим хаягаар нь илгээнэ
- 5.5. Мэргэжлийн боловсролын болон бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтад элсэхийг хүсэгч ХСИС-ийн [www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn) хаягаар нэвтрэн орж, цахим бүртгэлийн програмаас өгөгдөх зааварчилгааны дагуу мэдээллээ оруулан “Бүртгэлийн сан”-д бүртгүүлнэ.
- 5.5.1. Элсэлтийн шалгалтын комисс нь мэргэжлийн боловсролын болон бакалаврын зэрэг олгох сургалтад элсэхийг хүсэгчдийн ерөнхий шалгалтын дүн Боловсролын үнэлгээний төвөөс зарлагдсаны дараа уг төвөөс суурь ба хавсралт шалгалтын оноонуудыг татан авч, чанарын онооны томьёонд шилжүүлэн тухайн хичээлийн жилийн элсэлтийн шалгалтын босго онооны болзол хангасан элсэхийг хүсэгчдийн жагсаалтыг гарган их сургуулийн элсэлтийн “Бүртгэлийн сан”-д байршуулна.
- 5.5.1.1. Жагсаалтад багтсан элсэхийг хүсэгч цахим бүртгэлийн сангаас суурь, хавсралт шалгалтын оноо ба чанарын оноо бүхий “Шалгалтын хуудас”-аа хэвлэн авснаар ХСИС-ийн элсэлтийн нэмэлт шалгалтад орох эрх үүснэ.
- 5.5.2. Цахим бүртгэлийн санд бүртгүүлсэн магистр, докторын сургалтад элсэхийг хүсэгчид тухайн сонгосон сургалтын хэлбэрт тавих шаардлагыг хангасан эсэхийг цахим хаягаар нь мэдээлнэ.
- 5.5.3. Магистр, докторын зэрэг олгох сургалтад тавих шаардлагыг хангасан тухай мэдээлэл авсан элсэхийг хүсэгч, холбогдох нотлох баримт бичгүүдийг бүрдүүлэн өөрийн биеэр бүртгүүлнэ.
- 5.6. Удирдлагын сургуульд элсэхийг хүсэгчийг захиалагч агентлаг, байгууллагуудын Хүний нөөцийн холбогдох нэгжийн албан бичгээр ирүүлсэн нэрсийн жагсаалтыг үндэслэн бүртгэнэ.

**ЗУРГАА. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:**

- 6.1. Мэргэжлийн боловсролын сургалтын элсэлтийн шалгалтын дэгийг “ХСИС-ийн мэргэжлийн боловсрол олгох болон мэргэжлийн сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журам”-аар;
- 6.2. Бакалаврын зэрэг олгох сургалтын элсэлтийн шалгалтын дэгийг “ХСИС-ийн бакалаврын сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журам”-аар;
- 6.3. Магистр, докторын зэрэг олгох сургалтын элсэлтийн шалгалтын дэгийг “ХСИС-ийн магистр, докторын сургалтын элсэлтийн журам”-аар;
- 6.4. Удирдлагын сургуулийн элсэлтийн шалгалтын дэгийг “Удирдлагын сургуульд элсүүлэн суралцуулах журам”-аар тус тус тогтооно.

#### **ДОЛОО. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧИЙГ СУДЛАХ**

- 7.1. ХСИС-ийн элсэлтийн комисс нь мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүсэгчийг Хууль сахиулах албанд анх орох, суралцах иргэнд тавих тусгай шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлох судалгаанд хамруулах ажиллагааг зохион байгуулна.
- 7.2. ХСИС-ийн элсэлтийн комисс судалгааны чиглэл, шалгуур, арга хэлбэр, хугацааг захиалагч агентлагуудын холбогдох нэгжтэй зөвшилцөн, тухайн сургалтын элсэлтийн журмаар тогтооно.
- 7.3. Судалгаанд Хууль зүйн яамны харьяа захиалагч агентлагуудын холбогдох нэгжүүд шаардлагатай мэдээллээр шуурхай ханган, дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.
- 7.4. Судалгаанд тэнцээгүй элсэгчийг хяналтын тооноос хасаж, тэнцсэн элсэгчдийн жагсаалтын дараачийн элсэгчид суралцах эрхийг шилжүүлэн олгоно.
- 7.5. Судалгааны дүнг цахим хаягаар судалгаанд хамрагдсан элсэгчид илгээх ба их сургуулийн байрлал дахь мэдээллийн самбар, ХСИС-ийн [www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn) вэб хуудсаар дамжуулан нийтэд зарлана.

#### **НАЙМ. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧДЭД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ**

- 8.1. Хууль сахиулах албан үүрэг гүйцэтгэх явцдаа онцгой гавьяа байгуулсан, тухайн агентлаг, байгууллагын ажил мэргэжлийн болон хөдөлмөрийн аваргаар шалгарсан, спортын өндөр амжилт гаргасан алба хаагчийг харьяа агентлагийн саналыг үндэслэн хөнгөлөлттэй нөхцөлөөр элсүүлэн суралцуулж болно.
- 8.2. Суурь ба хавсралт шалгалт өгсөн хичээлээр сүүлийн нэг жилд олон улсын болон улсын олимпиад, уралдаанд шагналт байранд шалгарсан элсэхийг хүсэгчид хөнгөлөлт үзүүлж болно.
- 8.3. Энэ журмын 8.1 дэх хэсэгт заасан хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцах элсэгчийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноо нь авбал зохих босго онооны 70 хувиас багагүй байна.
- 8.4. Бүртгэгдсэн элсэхийг хүсэгчдээс олон улс, тив, дэлхий, олимпийн спортын уралдаан тэмцээнд оролцож 1-3 дугаар байранд шалгарсан, спортын болон олон улсын хэмжээний мастерын зэрэгтэй тамирчдыг 6.1.3.1 дэх заалтад заасан “Бие бялдар”-ын шалгалтаас чөлөөлж авбал зохих дээд оноогоор тооцно.
- 8.5. Хууль сахиулахын их сургуулийг бакалаврын зэрэгтэй төгсөгчийг “Төгсөлтийн шалгалт”-ын комиссоос магистрын сургалтад, магистрын зэрэгтэй төгсөгчийг “Хамгаалуулах зөвлөл”-өөс докторын сургалтад суралцах урилга өгсөн бол элсэлтийн шалгалтгүйгээр суралцуулна.
- 8.6. Энэ журмын 8.1-8.5 дахь хэсгүүдэд хамаарах хөнгөлөлттэй нөхцлөөр элсүүлэн суралцуулах асуудлыг салбар комиссын хуралдаанаар хэлэлцэж, төв комиссын даргад танилцуулж, шийдвэрлэнэ.

#### **ЕС. ЭЛСЭГЧИЙГ БҮРТГЭХ**

- 9.1. ХСИС-ийн боловсролын зэрэг олгох бүх төвшний сургалтын элсэлтийн шалгалтад тэнцсэн элсэгчийг тухайн төвшний сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журмаар тогтоосон хугацаанд холбогдох баримт бичгүүдийн эх хувийг үндэслэн бүртгэнэ.
- 9.2. Элсэгч журмаар тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй тохиолдолд суралцахаас сайн дураараа татгалзсанд тооцож хасах бөгөөд тэнцсэн элсэгчдийн нэрсийн жагсаалтын дагуу дараагийн элсэхийг хүсэгчид суралцах эрхийг шилжүүлэн олгоно.

#### **АРАВ. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТТАЙ ХОЛБООТОЙ ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХ**

- 10.1. Элсэлттэй холбоотой өргөдөл, гомдол, хүсэлтийг салбар комиссын даргад гаргана.
- 10.2. Иргэнээс гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг зөвхөн тухайн төвшний сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журмаар заасан хугацаанд хүлээн авч, шийдвэрлэнэ.

#### **АРВАН НЭГ. ШИЙДВЭР ГАРГАХ**

- 11.1. Төв комисс боловсролын зэрэг олгох сургалтын бүх төвшний элсэлтийн шалгалтад тэнцэж, хяналтын тоонд багтсан элсэгчийн цахим хаягаар тухайн сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журмаар тогтоосон хугацаанд “Тэнцсэн” тухай мэдээллийг илгээх ба их сургуулийн байрлал дахь мэдээллийн самбар, ХСИС-ийн “[www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn)” вэб хуудсаар дамжуулан нийтэд зарлана
- 11.2. Төв комисс боловсролын зэрэг олгох сургалтын бүх төвшний элсэлтийн шалгалтад тэнцэж, хяналтын тоонд багтсан элсэгчдийн оноо, нэрсийг ХСИС-ийн захиралд танилцуулна.
- 11.3. ХСИС-ийн захирал тэнцсэн элсэхийг хүсэгчийн суралцах эрхийг тушаал гаргаж, баталгаажуулна.
- 11.4. ХСИС-ийн захирлын элсүүлэн суралцуулах тушаал, элсэгчдийн нэрсийг захиалагч агентлагуудын холбогдох нэгжид тухайн төвшний сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журмаар тогтоосон хугацаанд хүргүүлнэ.
- 11.5. Захиалагч агентлаг, байгууллагуудын холбогдох нэгж элсэгчдийн суралцах эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 11.6. ХСИС-ийн элсэлтийн төв комиссын дарга элсэлтийн шалгалтын зохион байгуулалт, явц, үр дүнгийн тайланг Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн даргад тайлагнана.

**АРВАН ХОЁР. ЖУРАМ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

- 12.1. Энэхүү журмыг зөрчигчдөд холбогдох хууль, тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 12.2. Элсэлтийн цахим бүртгэлийн санд бүртгүүлсэн мэдээллийг холбогдох баримт бичгүүдийн эх хувьтай тулгаж, худал мэдүүлсэн тохиолдолд хүчингүйд тооцож, тэнцсэн элсэгчдийн жагсаалтаас хасна.
- 12.3. Элсэгчийн иргэний болон боловсролын үнэмлэх, диплом, бусад баримт бичиг засвартай, хуурамч болох нь тогтоогдсон тохиолдолд элсэгчдийн жагсаалтаас хасаж, уг бичиг баримтыг шалгуулахаар харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлнэ.
- 12.4. Элсэлтийн шалгалтын үйл ажиллагаатай холбоотой учирсан хохирлыг буруутай этгээд бүрэн хариуцна.

**СУРГАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**



**ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН 2014-2015 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН  
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ БОЛОН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН  
ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1. Хууль сахиулахын их сургуулийн /цаашид ХСИС гэх/ шаталсан сургалтын мэргэжлийн боловсрол олгох болон мэргэжлийн сургалтад суралцагч элсүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.
2. ХСИС-ийн мэргэжлийн боловсрол, сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журам нь /цаашид МБСЭЖ гэх/ Монгол Улсын “Боловсролын тухай”, “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2006 оны 189 дүгээр тушаалын хавсралт “Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам”, 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, “ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам”, захиалагч агентлагуудын хүний нөөцийг бэлтгэх, сонгон шалгаруулахтай холбогдох харилцааг зохицуулсан бусад хууль, эрх зүйн актуудад нийцсэн байна.
3. МБСЭЖ-ыг “ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам”-ыг үндэслэн жил бүр шинэчлэн боловсруулж, элсэлтийн шалгалтын төв комисс /цаашид төв комисс гэх/-ын хуралдаанаар хэлэлцүүлэн ХСИС-ийн захирлаар батлуулж, мөрдөнө.
4. ХСИС-ийн МБСЭЖ-аар мэргэжлийн боловсрол олгох болон мэргэжлийн сургалтад элсүүлэн суралцуулах мэргэжлийн чиглэл, шалгалтын төрөл, агуулга, дэг, суурь ба хавсралт шалгалтын босго оноог тогтоож, чанарын оноог бодох аргачлал, элсэлт зохион байгуулах хугацаа зэргийг тогтооно.
5. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын элсэлтийн шалгалтыг ХСИС-ийн захирлын тушаалаар батлагдсан салбар комисс зохион байгуулна.
6. МБСЭЖ-д хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно.
  - 6.1. “**Мэргэжлийн боловсрол**” гэж тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж, зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшилийг;
  - 6.2. “**Мэргэжлийн сургалт**” гэж тодорхой ажил хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх үйл ажиллагааг;
  - 6.3. “**Бүртгэлийн сан**” гэж элсэлтийн цахим бүртгэлийн мэдээллийг;
  - 6.4. “**Элсэхийг хүсэгч**” гэж ХСИС-ийн элсэлтийн бүртгэлийн санд бүртгүүлсэн иргэнийг;
  - 6.5. “**Элсэгч**” гэж зохих шаардлага, шалгуурыг хангаж, элсэлтийн хяналтын тоонд багтсан элсэхийг хүсэгчийг;
  - 6.6. “**Элсэлтийн шалгалтын комисс**” гэж элсэлтийн шалгалтыг зохион байгуулахаар томилогдсон бүрэлдэхүүнийг;
  - 6.7. “**Нэмэлт шалгалт**” гэж сургууль өөрийн онцлогт тохируулан авч буй бие бялдар, сэтгэл зүйн сорил, ярилцлагыг;
  - 6.8. “**Шалгалтын хуудас**” гэж элсэхийг хүсэгчийн шалгалтын оноо, үнэлгээний мэдээлэл бүхий хуудсыг;
  - 6.9. “**МБ-БДБ**” гэж мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүссэн бүрэн дунд болон тусгай дунд боловсролтой иргэнийг;
  - 6.10. “**МБ-ДБ**” гэж мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүссэн дээд боловсролтой иргэн гэж тус тус ойлгоно.
7. Элсэлтийн шалгалтын комисс нь /цаашид элсэлтийн комисс гэх/ шалгалтыг хууль ёсны, шударга, ил тод, нээлттэй байх, мэдээллийн хүртээмжтэй, шуурхай байдлыг хангах, зарчмуудыг удирдлага болгон хараат бусаар бие даан зохион байгуулна.
8. Энэхүү журам болон “ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам”, холбогдох бусад мэдээллийг ХСИС-ийн [www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn) болон захиалагч агентлаг, байгууллагуудын цахим хуудсанд байршуулна.

**ХОЁР. СУРАЛЦУУЛАХ МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ, СУРГАЛТЫН ХЭЛБЭР**

- 2.1. ХСИС нь Хөдөлмөрийн яамнаас олгосон “Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийн хүрээнд шаталсан сургалтын мэргэжлийн боловсрол олгох болон мэргэжлийн сургалтыг явуулна.

2.1.1. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын төвшинд суралцуулах чиглэл:

Д/д	Суралцах мэргэжил	Шалгалтын чиглэл			Хугацаа	Харьяалал
		Суурь	Хавсралт	Нэмэлт		
<b>Өдрийн сургалт</b>						
1	Цагдаа	Нийгмийн тухай мэдлэг /560 оноо/	Математик /400 оноо/	Чанарын оноог томъёогоор бодно	Бие бялдрын шалгалт, сэтгэл зүйн сорил, ярилцлага	1 жил
2	Хилийн харуулын дарга		Гадаад хэл /Англи, Орос/ /400 оноо/			
3	Хилийн шалган нэвтрүүлэх албаны шалгагч					
4	Харуул хамгаалалтын албаны ажилтан					
5	Аврагч		Математик /560 оноо/			

2.1.1.1. Ерөнхий шалгалтын суурь ба хавсралт шалгалтын чанарын оноог дараах томъёогоор бодно:

$$K = \frac{(a * 1,5) + b}{2}$$

a=суурь шалгалтын оноо

b=хавсралт шалгалтын оноо

2.1.1.2. Урьд нь дээд боловсрол эзэмшсэн элсэхийг хүсэгчийн бакалаврын дипломын голч дүнг чанарын оноонд дараах томъёогоор шилжүүлнэ.

$$K = \frac{C * 1000}{4}$$

C= Элсэхийг хүсэгчийн бакалаврын дипломын голч дүн

1000= Ерөнхий шалгалтын чанарын онооны авбал зохих дээд үнэлгээ

4= Голч дүнгийн авбал зохих дээд үнэлгээ

2.1.2. Мэргэжлийн сургалтад суралцуулах чиглэл:

Д/д	Мэргэжлийн чиглэл	Шалгалтын чиглэл			Хугацаа	Харьяалал
		Шалгалт 1	Шалгалт 2	Шалгалт 3		
<b>Өдрийн сургалт</b>						
1	Цагдаа	Монгол хэлний найруулга зүй	Бие бялдрын шалгалт	Сэтгэл зүйн сорил	1-4 сар	Ахлагчийн сургууль
2	Цагдаа-жолооч					
3	Цагдаа-Замын хөдөлгөөний зохицуулагч					
4	Аврагч-Гал сөнөөгч					
5	Аврагч- Гал унтраах автомашины жолооч					
6	Харуул хамгаалалтын албаны ажилтан					
7	Харуулын дарга					
8	Шалгагч					
9	Офицер дамжаа					
10	Гэрээт харуул хамгаалалтын албаны алба хаагч					

2.2. Хууль зүйн яамны харьяа захиалагч агентлагууд нь тухайн жилд мэргэжлийн боловсролын сургалтад элсүүлэх мэргэжлийн чиглэл, нас хүйс, хяналтын тоог 2014 оны 04 дүгээр сарын 01-ний дотор ХСИС-д ирүүлнэ.

2.3. ХСИС захиалгат боловсон хүчнийг бэлтгэх эрэлт, хэрэгцээ, шаардлага, боломж, нөхцөлийг судлан, Хууль зүйн яамтай зөвшилцөн элсэлтийн хяналтын тоог тогтоон, Хөдөлмөрийн ямаар батлуулна.

2.4. Элсэлтийн комисс нь Хөдөлмөрийн яамнаас баталсан хяналтын тооны хүрээнд мэргэжлийн боловсрол олгох сургалтын элсэлтийн шалгалтыг; агентлагуудын захиалсан эрэлт хэрэгцээт мэргэжлийн чиглэл, хугацаанд үндэслэн мэргэжлийн сургалтын элсэлтийн шалгалтыг тус тус зохион байгуулна.

2.5. ХСИС нь мэргэжлийн боловсрол олгох болон мэргэжлийн сургалтыг өдрийн хэлбэрээр зохион байгуулна.

2.6. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын хугацаа нь 1 жил, мэргэжлийн сургалтын хугацаа нь 1-4 сар байна.

**ГУРАВ. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧИД ТАВИХ ШААРДЛАГА**

3.1. ХСИС-ийн мэргэжлийн боловсрол олгох болон мэргэжлийн сургалтад элсэхийг хүсэгчид тавих

шаардлага нь эзэмшсэн боловсрол, суралцах мэргэжлийн чиглэл, суралцах хугацаа, захиалагч агентлагуудын хүний нөөцийг бэлтгэх, сонгон шалгаруулахтай холбогдсон эрх зүйн актуудаар тодорхойлсон шаардлагуудаас хамааран ялгамжтай байна.

- 3.1.1. Мэргэжлийн боловсролын сургалтад элсэхийг хүсэгч нь бүрэн болон тусгай дунд, дээд боловсрол эзэмшсэн Монгол Улсын иргэн байна.
- 3.1.2. Мэргэжлийн сургалтад элсэхийг хүсэгч нь Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Хил хамгаалах, Онцгой байдлын албанд ажиллахыг сайн дураар хүссэн, 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн байна.
- 3.2. ХСИС-ийн мэргэжлийн боловсрол олгох болон мэргэжлийн сургалтад элсэхийг хүсэгчид тавих нийтлэг шаардлага:
  - 3.2.1. Нүүрний хэлбэр төрх зөв, ил харагдах 20X05 мм-ээс том сорви, шивээсгүй, бие эрхтний гэмтэл согоггүй, эрүүл байх;
  - 3.2.2. Биеийн өндөр: Эрэгтэй 165 см ба түүнээс дээш, эмэгтэй 160 см ба түүнээс дээш байх;
  - 3.2.3. Мэргэжлийн боловсрол олгох болон мэргэжлийн сургалтын төвшинд элсэхийг хүсэгчид тавих насны хязгаарт нийцсэн байх;
    - 3.2.3.1. ХСИС-ийн шаталсан сургалтын мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүсэгч эрэгтэй 17-25, эмэгтэй 17-20 хүртэл настай байх;
    - 3.2.3.2. Мэргэжлийн сургалтад элсэхийг хүсэгч нь захиалагч агентлагуудын хүний нөөцийг бэлтгэх, сонгон шалгаруулахтай холбогдох харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн актуудаар тогтоосон насны хязгаарт нийцсэн байх;
- 3.3. Тусгай шаардлага:
  - 3.3.1. Мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүсэгчид тавих тусгай шаардлага:
    - 3.3.1.1. Бүрэн дунд болон тусгай дунд боловсрол эзэмшсэн элсэхийг хүсэгчийн ерөнхий шалгалтын батламж хүчинтэй, суурь ба хавсралт шалгалтын оноо нь энэ журмын 2.1.1 дэх заалтад заасан болзлыг хангаж байх;
    - 3.3.1.2. Урьд нь дээд боловсрол эзэмшсэн элсэхийг хүсэгчийн бакалаврын боловсролын дипломын голч дүн 2.4 буюу түүнээс дээш байх/;
  - 3.3.2. Мэргэжлийн сургалтад элсэхийг хүсэгчид тавих тусгай шаардлага:
    - 3.3.2.1. Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан болзол болон захиалагч агентлагуудын хүний нөөцийг бэлтгэх, сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулж буй бусад хууль, эрх зүйн актуудаар тодорхойлсон шаардлагуудыг хангасан байх;
    - 3.3.2.2. Энэ журмын 3.3.2.1 дэх заалтад заасан шаардлагыг хангаж, захиалагч агентлаг, байгууллагаас элсэлтийн шалгалтад орохыг дэмжсэн зөвшөөрөл авсан байх;
    - 3.3.2.3. Цэргийн алба хаасан байх;/захиалагч агентлагийн шаардлагыг харгалзана./

#### **ДӨРӨВ. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧИЙГ БҮРТГЭХ**

- 4.1. Элсэхийг хүсэгч ХСИС-ийн [www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn) хаягаар нэвтрэн орж, элсэлтийн бүртгэлийн санд цахим хэлбэрээр 2014 оны 04 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 31-ний 18.00 цаг хүртэл зөвхөн нэг мэргэжлийн чиглэлээр бүртгүүлнэ.
- 4.2. Бүртгүүлэхийн өмнө энэ журам болон "ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам", бусад нэмэлт мэдээллүүдтэй танилцсан байна.
- 4.3. Мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүсэгч бүртгэлийн сангийн "МБ-БДБ"/мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүссэн бүрэн дунд, тусгай дунд боловсролтой иргэн/, "МБ-ДБ"/мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүссэн дээд боловсролтой иргэн/ цэснээс тохирохыг сонгон цахим бүртгэлийн програмаас өгөгдөх зааварчилгааны дагуу мэдээллээ оруулан бүртгүүлнэ.
- 4.4. Бүртгүүлсэн элсэхийг хүсэгчид хувийн нууц код олгож, цахим хаягаар нь илгээнэ.
- 4.5. Элсэлтийн шалгалтын комисс нь элсэлтийн ерөнхий шалгалтын дүн Боловсролын үнэлгээний төвөөс зарлагдсаны дараа уг төвөөс ХСИС-ийн шаталсан сургалтын мэргэжлийн боловсрол олгох төвшинд элсэхийг хүссэн бүрэн дунд боловсролтой элсэхийг хүсэгчийн суурь ба хавсралт шалгалтын оноог татан авч, чанарын оноог тооцно. /Энэ журмын 2.1.1.1-т заасан томъёогоор бодно/
- 4.6. Элсэхийг хүсэгчдийг чанарын онооны буурах эрэмбээр жагсааж, жагсаалтыг ХСИС-ийн элсэлтийн цахим сайтад байршуулан, их сургуулийн байрлал дахь мэдээллийн самбар, ХСИС-ийн "[www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn)" вэб хуудсаар дамжуулан нийтэд зарлах ба цахим хаягаар нь илгээнэ.
- 4.7. Жагсаалтад багтсан элсэхийг хүсэгч элсэлтийн комиссоос бүртгэлийн сан дахь шалгалтын хуудсанд нь суурь ба хавсралт шалгалтын оноо, чанарын оноог оруулсны дараа "Шалгалтын хуудас"-аа хэвлэн авна.

- 4.8. Шалгалтын хуудас бүхий элсэхийг хүсэгчид ХСИС-ийн мэргэжлийн боловсрол олгох сургалтын элсэлтийн нэмэлт шалгалтад орох эрх үүснэ.
- 4.9. Мэргэжлийн сургалтад элсэхийг хүсэгчийг захиалагч агентлагуудын холбогдох нэгжийн бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн арга зүйч бүртгэж, улмаар тухайн сургалтын хугацаанд элсэгчдийн мэдээллийг ХСИС-ийн элсэлтийн цахим бүртгэлийн санд оруулах үүргийг хүлээнэ.

**ТАВ. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:**

- 5.1. Мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсүүлэх шалгалтыг дараах дэгийн дагуу зохион байгуулна.
- 5.1.1. “Шалгалтын хуудас” бүхий элсэхийг хүсэгч энэ журмын 3.2 дахь хэсэгт заасан элсэхийг хүсэгчид тавих нийтлэг шаардлагыг хангасан эсэхийг тогтоох үзлэгт 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс 2014 оны 07 дугаар сарын 03-ны өдрүүдэд 08.30-17.00 цагт хамрагдана;
- 5.1.2. Энэ журмын 5.1.1 дэх заалтад заасан үзлэгт тэнцсэн элсэхийг хүсэгч элсэлтийн комиссын зохион байгуулалт дор “Батлан хамгаалах, Хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг”-т эрүүл мэндийн үзлэгт 2014 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс 2014 оны 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд 08.00-16.00 цагт орж, дүгнэлт гаргуулна;
- 5.1.3. Энэ журмын 5.1.2 дахь заалтад эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн элсэхийг хүсэгч нэмэлт шалгалт /бие бялдрын шалгалт, сэтгэл зүйн сорил, ярилцлага/ өгнө;
- 5.1.3.1. Энэ журмын 5.1.1, 5.1.2 дахь заалтуудад заасан шаардлагыг хангасан элсэхийг хүсэгчээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Е-21 дүгээр албан даалгавар, Хилийн цэрэг, Онцгой байдал, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын бие бялдрын нормативтай харьцуулан боловсруулсан “ХСИС-д шинээр элсэн суралцах сонсогчоос авах бие бялдрын шалгалтын шалгуур үзүүлэлт”-ийн дагуу “Бие бялдар”-ын шалгалтыг 2014 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс 2014 оны 07 дугаар сарын 08-ны өдрүүдэд 08.30-17.00 цагт ХСИС-ийн байрлалд авна.

**А. “Бие бялдар”-ын шалгалт. 18-25 нас Эрэгтэй**

Д/д	Хуч	Тэсвэр	Хурд	Авхаалж самбаа	Уян хатан	Оноо
	Гар дээр сунналт	1000м	100м	Цогцолбор дасгал	Сууж урагш бөхийх	
1.	62	3.15	14.00	115	65	20
2.	60	3.20	14.10	114	64	19
3.	58	3.25	14.20	113	63	18
4.	56	3.30	14.30	112	62	17
5.	54	3.35	14.40	111	61	16
6.	52	3.40	14.50	110	60	15
7.	50	3.45	14.60	109	59	14
8.	48	3.50	14.70	108	58	13
9.	46	3.55	14.80	107	57	12
10.	44	4.00	14.90	106	56	11
11.	42	4.05	15.00	105	55	10
12.	40	4.10	15.10	104	54	9
13.	39	4.15	15.20	103	53	8
14.	38	4.20	15.30	102	52	7
15.	37	4.25	15.40	101	51	6
16.	36	4.30	15.50	100	50	5
17.	35	4.35	15.60	99	49	4
18.	34	4.40	15.70	98	48	3
19.	33	4.45	15.80	97	47	2
20.	32	4.50	15.90	96	46	1

**Б. “Бие бялдар”-ын шалгалт 18-25 нас Эмэгтэй**

д/д	Хуч	Тэсвэр	Хурд	Авхаалж самбаа	Уян хатан	Оноо
	Гар дээр сунналт	1000м	100м	Цогцолбор дасгал	Сууж урагш бөхийх	
1.	40	3.50	15.00	90	65	20
2.	38	3.55	15.10	89	64	19
3.	36	3.60	15.20	88	63	18
4.	34	4.00	15.30	87	62	17

5.	32	4.05	15.40	86	61	16
6.	30	4.10	15.50	85	60	15
7.	28	4.15	15.60	84	59	14
8.	26	4.20	15.70	83	58	13
9.	24	4.25	15.80	82	57	12
10.	22	4.30	15.90	81	56	11
11.	18	4.35	16.00	80	55	10
12.	16	4.40	16.10	79	54	9
13.	14	4.45	16.20	78	53	8
14.	12	4.50	16.30	77	52	7
15.	10	4.55	16.40	76	51	6
16.	8	4.60	16.50	75	50	5
17.	6	5.00	16.60	74	49	4
18.	4	5.05	16.70	73	48	3
19.	2	5.10	16.80	72	47	2
20.	1	5.15	16.90	71	46	1

- 5.1.3.1.1. Бие бялдрын шалгалтын "Хүч", "Тэсвэр", "Уян хатан", "Хурд", "Авхаалж самбаа" гэсэн 5 чанарын аль нэгд нь шалгуулаагүй буюу "0" оноо авсан тохиолдолд тус шалгалтад тэнцээгүйд тооцно.
- 5.1.3.1.2. Бие бялдрын шалгалтад авбал зохих нийт онооны 50 хувь нь тус шалгалтын босго оноо байна.
- 5.1.3.2. "Сэтгэл зүйн сорил"-ыг мэргэжлийн стандарт сорил, судалгааны аргуудыг ашиглан явуулахаар "ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам"-ын 2.6.6-д зааснаар урьдчилан бэлтгэж, 2014 оны 07 дугаар сарын 09-ний 09.00 цагаас эхлэн зохион байгуулж, дүгнэнэ.
- 5.1.3.2.1. Сэтгэл зүйн сорилоор иргэний анхаарал, ой тогтоолт, сэтгэн бодох чадвар зэрэг танин мэдэхүйн үйл явц, оюун ухааны хөгжлийн төвшинг тодорхойлж, дүгнэлт гаргана.
- 5.1.3.2.2. "Сэтгэл зүйн сорил"-д оролцогчдод "Тэнцэнэ", "Тэнцэхгүй" гэсэн үнэлгээ өгнө. "Тэнцэхгүй" гэсэн үнэлгээ авсан элсэхийг хүсэгчийг хэл яриа, мэдрэл, сэтгэл зүйн чиглэлийн мэргэжлийн эмчид хандан нарийвчилсан үзлэгт оруулж эмнэлгийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.
- 5.1.4. Нэмэлт шалгалтыг дахин болон нөхөн авахгүй.
- 5.1.5. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын элсэлтийн шалгалтад орсон бүрэн дунд боловсролтой элсэхийг хүсэгчдийн ерөнхий шалгалтын чанарын оноо /энэ журмын 2.1.1.1 дэх заалтад заасан томъёогоор тооцсон/ ба бие бялдрын шалгалтын онооны нийлбэрийг, дээд боловсролтой элсэхийг хүсэгчдийн бакалаврын дипломын голч дүнг чанарын оноонд шилжүүлэн /энэ журмын 2.1.1.2 дахь заалтад заасан томъёогоор тооцсон/ бие бялдрын шалгалтын оноог нэмж, нийлбэрийг буурах эрэмбээр жагсаан, мэргэжил тус бүрийн хяналтын тоонд багтаан шалгаруулж, их сургуулийн байрлал дахь мэдээллийн самбар, ХСИС-ийн "[www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn)" вэб хуудсаар дамжуулан нийтэд зарлана.
- 5.2. Мэргэжлийн сургалтын элсэлтийн шалгалтыг дараах дэгийн дагуу зохион байгуулна.
- 5.2.1. Захиалагч агентлагуудын холбогдох нэгж ажилд орохоор хүсэлт гаргасан иргэдийг судалгаанд хамруулж, тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан иргэдийн нэрсийг бичгээр мэргэжлийн сургалтад хамруулахаар ХСИС-д хүргүүлэх ба үүнийг үндэслэн ХСИС-ийн элсэлтийн комисс шалгалтыг зохион байгуулна.
- 5.2.2. Мэргэжлийн сургалтын элсэлтийн шалгалтыг ХСИС-ийн элсэлтийн комисс захиалагч агентлаг, байгууллагын онцлог, шаардлагад нийцүүлэн боловсруулсан шалгалтын удирдамжийн дагуу зохион байгуулна.
- 5.2.3. Мэргэжлийн сургалтад элсэхийг хүсэгч бие бялдар, монгол хэлний найруулга зүй, сэтгэл зүйн сорилын шалгалтуудыг өгнө.
- 5.2.3.1. Мэргэжлийн сургалтад элсэхийг хүсэгчдээс бие бялдрын шалгалтыг дараах үзүүлэлтээр авна.

**А. "Бие бялдар"-ын шалгалт.**

**Эрэгтэй**

д/д	Хүч	Тэсвэр	Хурд	Авхаалж самбаа	Хүч	Оноо
	Гар дээр суниалт	1000м	10x10м/сек/	Цогцолбор дасгал	Савлуурт суних	
21.	62	3.15	27.0	110	20	20

22.	60	3.20	27.20	109	19	19
23.	58	3.25	27.40	108	18	18
24.	56	3.30	27.60	107	17	17
25.	54	3.35	27.80	106	16	16
26.	52	3.40	28.00	105	15	15
27.	50	3.45	28.20	104	14	14
28.	48	3.50	28.40	103	13	13
29.	46	3.55	28.60	102	12	12
30.	44	4.00	28.80	101	11	11
31.	42	4.05	29.00	100	10	10
32.	40	4.10	29.20	99	9	9
33.	39	4.15	29.40	98	8	8
34.	38	4.20	29.60	97	7	7
35.	37	4.25	29.80	96	6	6
36.	36	4.30	30.00	95	5	5
37.	35	4.35	30.20	94	4	4
38.	34	4.40	30.40	93	3	3
39.	33	4.45	30.60	92	2	2
40.	32	4.50	30.80	91	1	1

**Б. "Бие бялдар"-ын шалгалт.**

**Эмэгтэй**

Д/Д	Хүч	Тэсвэр	Хурд	Авхаалж самбаа	Хүч	Оноо
	Гар дээр суниалт	1000м	10х10м /сек/	Цогцолбор дасгал	Гэдэс таталт	
1.	40	4.10	31.00	90	56	20
2.	38	4.15	31.20	89	55	19
3.	36	4.20	31.40	88	54	18
4.	34	4.25	31.60	87	53	17
5.	32	4.30	31.80	86	52	16
6.	30	4.35	32.00	85	51	15
7.	28	4.40	32.20	84	50	14
8.	26	4.45	32.40	83	49	13
9.	24	4.50	32.60	82	48	12
10.	22	4.55	32.80	81	47	11
11.	18	5.00	33.00	80	46	10
12.	16	5.05	34.00	79	45	9
13.	14	5.10	34.20	78	44	8
14.	12	5.15	34.40	77	43	7
15.	10	5.20	34.60	76	42	6
16.	8	5.25	34.80	75	41	5
17.	6	5.30	35.00	74	40	4
18.	4	5.35	35.20	73	39	3
19.	2	5.40	35.40	72	38	2
20.	1	5.45	35.60	71	37	1

5.2.3.2. Монгол хэлний найруулга зүйн шалгалтыг өгөгдсөн сэдвээр эссе бичүүлж, удирдамжаар тогтоосон журмын дагуу үнэлж, дүгнэнэ. .

5.2.3.3. Сэтгэл зүйн сорилыг энэ журмын 5.1.3.2.1 дэх заалтад заасны дагуу авна.

5.3. Мэргэжлийн сургалтад элсэхийг хүсэгчдийг энэ журмын 5.2.3.1-5.2.3.3 дахь заалтад заасан шалгалтуудын нийлбэр оноогоор буурах эрэмбээр жагсааж, хяналтын тоонд багтаан шалгаруулж, их сургуулийн байрлал дахь мэдээллийн самбар, ХСИС-ийн "[www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn)" вэб хуудсаар дамжуулан нийтэд зарлана.

**ЗУРГАА. ХСИС-ИЙН ШАТАЛСАН СУРГАЛТЫН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТАД ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧИЙГ СУДАЛГААНД ХАМРУУЛАХ**

- 6.1. ХСИС-ийн мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэхийг хүсэгчийг Хууль сахиулах албанд анх орох, суралцах иргэнд тавих тусгай шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлох судалгаанд 2 үе шаттайгаар хамруулна.
- 6.2. Судалгааг дараах чиглэлээр захиалагч, агентлаг байгууллагуудын холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулна.

№	Судалгааны чиглэл	Судлах хугацаа	Судалгааны үе шат		Хамрах хүрээ	Хариуцан зохион байгуулах
			Шалгалтын	Шалгалтын		

			явцад	дараа		
1	Бие бялдар, гоо зүйн шаардлага буюу элсэлтийн нийтлэг журмын 4.2 дахь хэсэгт заасан нийтлэг шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлох судалгаа	2014.07.02-2014.07.03	+		Нийт элсэхийг хүсэгчид	ХСИС-ийн элсэлтийн комисс
2	Эрүүл мэндийн судалгаа	2014.07.04-2014.07.05	+			БХХСАХНЭ
3	Сэтгэл зүйн байдлыг байдлыг шалгах сорил, судалгаа	2014.07.09-2014.07.10	+		Бие бялдрын шалгалтад тэнцсэн элсэхийг хүсэгчид	ХСИС-ийн элсэлтийн комисс
4	Бичиг баримтын судалгаа	2014.07.16-2014.07.18		+		
5	Ял шийтгэгдэж байсан эсэхийг шалгах	2014.07.16-2014.07.18		+	Элсэлтийн шалгалтад тэнцсэн нийт элсэгчид	Захиалагч агентлагууд
6	Ёс зүй, зан байдал, хандлагын судалгаа	2014.07.09-2014.07.25		+		

- 6.3. Судалгааны аль нэг чиглэлийн шаардлагыг хангаагүй элсэхийг хүсэгчийн суралцах эрхийг татгалзан тэнцээгүйд тооцно.
- 6.4. Элсэлтийн комисс цахим бүртгэлийн сангаас судалгаанд шаардлагатай мэдээллийг агентлагуудын холбогдох нэгжид хүргүүлнэ.
- 6.5. Захиалагч агентлагуудын холбогдох нэгжүүд элсэхийг хүсэгчийн ёс зүй, зан байдал, хандлагын судалгааг 2014 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс 2014 оны 07 дугаар сарын 25-ны өдрүүдэд явуулж, элсэгчийн ёс зүй, зан байдал, хандлагын суурь үзүүлэлтийг тогтоон, мэргэжлийн зөв хандлагатай хууль сахиулагч төлөвшүүлэхэд сөргөөр нөлөөлөхүйц эрсдлийн үнэлгээг хийж, дүгнэлт гарган ХСИС-ийн элсэлтийн төв комисст ирүүлнэ.
- 6.6. Элсэгчийн ёс зүй, зан байдал, хандлагын суурь үзүүлэлтийг дараах шалгуур үзүүлэлтүүдээр судлан тогтоож, эрсдлийн үнэлгээг хийх нь сургалтын явцад "Мэргэжлийн зөв хандлагатай хууль сахиулагч" бэлтгэн төлөвшүүлэх зорилгыг агуулна. Үүнд:
1. Хууль сахиулах албаны ёс зүйн хэм хэмжээг чанд сахих хүсэл эрмэлзэл, чадвартай байх;
  2. Ёс суртахууны доголдолгүй байх;
  3. Шударга, зарчимч байх;
  4. Хорт муу зуршилгүй байх; /согтууруулах ундаа хэрэглэдэг болон бусад гаж, зуршилтай эсэх, мансууруулах бодис хэрэглэдэг эсэх /
  5. Зан байдлын төлөвшилд гэр бүл, ойрын төрөл садангийн хүмүүс болон найз нөхдийн зүгээс үзүүлэх сөрөг нөлөөлөл;
  6. Албаны онцлог нөхцөлд дасан зохицож, ажиллах чадвар, боломж; /алслагдмал орон зай, гэмт хэргийн газарт үзлэг шинжилгээ хийх, гэмт хэрэгтнүүдтэй ажиллах, байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйл, цаг агаар, гал, усны аюултай нөхцөлд ажиллах/ зэрэг болно.
- 6.7. Элсэлтийн комисс захиалагч агентлагуудын ирүүлсэн судалгааны дүгнэлтийг хэлэлцэн элсэгчийн тэнцэх эсэхийг тогтооно.
- 6.8. Судалгаанд тэнцээгүй элсэгчийг хяналтын тооноос хасаж, тэнцсэн элсэгчдийн жагсаалтын дараагийн элсэгчид суралцах эрхийг шилжүүлэн олгоно.
- 6.9. Судалгааны дүнг уг судалгаанд хамрагдсан элсэгчид цахим хаягаар нь илгээх ба сургуулийн байрлал дахь мэдээллийн самбар, ХСИС-ийн "[www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn)" вэб хуудсаар дамжуулан нийтэд зарлана.

#### **ДОЛОО. ЭЛСЭГЧИЙГ БҮРТГЭХ**

- 7.1. Энэ журмын 5.1.5 болон 6.2 дахь заалтад заасан шалгуурыг ханган элсэлтийн шалгалтад тэнцсэн элсэгчид ХСИС-д элсэн суралцах эрх үүснэ.
- 7.2. ХСИС-ийн шаталсан сургалтаар мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэн суралцах эрх үүссэн элсэхийг хүсэгчид 2014 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 09.00-16.00 цагуудад дараах баримт бичгийг бүрдүүлэн бүртгүүлнэ.
- 7.2.1. Иргэний үнэмлэх, /эх хувь ба нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт/;

- 7.2.2. Ерөнхий шалгалтын батламжийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
  - 7.2.3. Ерөнхий боловсролын гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
  - 7.2.4. Дээд боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;/
  - 7.2.5. 3Х4 хэмжээний 4 хувь зураг;
  - 7.2.6. Гурван үеийн намтар /өөрийн гараар дэлгэрэнгүй бичсэн байх/;
  - 7.2.7. Ерөнхий боловсролын сургуулийн тодорхойлолт;
  - 7.2.8. 3х4 хэмжээний 4 хувь чээж зураг;
  - 7.2.9. Эрүүл мэндийн үзлэгийн хуудас;
  - 7.2.10. Төрийн албан хаагчийн анкет /маягт 1,2/;
- 7.3. Элсэгч журмаар тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй тохиолдолд суралцахаас сайн дураараа татгалзсанд тооцож хасах бөгөөд тэнцсэн элсэгчдийн нэрсийн жагсаалтын дагуу дараагийн элсэхийг хүсэгчид суралцах эрхийг шилжүүлэн олгоно.

#### **НАЙМ. ШИЙДВЭР ГАРГАХ**

- 8.1. Салбар комисс мэргэжлийн боловсрол олгох сургалтын 5.1.5 болон 6.2 дахь хэсэг, мэргэжлийн сургалтын 5.3 дахь хэсэгт заасан шалгуурыг ханган элсэлтийн шалгалтад тэнцэж, хяналтын тоонд багтсан элсэгчдийн нэрсийг их сургуулийн байрлал дахь мэдээллийн самбар, ХСИС-ийн "[www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn)" вэб хуудсаар дамжуулан нийтэд зарлах ба цахим хаягаар нь илгээнэ.
- 8.2. Элсэлтийн төв комисс мэргэжлийн боловсролын болон мэргэжлийн сургалтад тэнцсэн элсэгчдийн нэрс, оноог хуралдаанаар хэлэлцэн, ХСИС-ийн захиралд танилцуулна.
- 8.3. ХСИС-ийн захирлын тушаалаар мэргэжлийн боловсрол олгох болон мэргэжлийн сургалтын элсэлтийн шалгалтад тэнцсэн элсэгчийн суралцах эрхийг баталгаажуулна.
- 8.4. ХСИС-ийн захирлын элсүүлэн суралцуулах тушаал, элсэгчдийн нэрсийг захиалагч агентлагуудын холбогдох нэгжид хүргүүлнэ.

#### **ЕС. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧДЭД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ**

- 9.1. Суурь ба хавсралт шалгалт өгсөн хичээлээр сүүлийн нэг жилд олон улсын болон улсын олимпиад, уралдаанд шагналт байранд шалгарсан элсэхийг хүсэгчид хөнгөлөлт үзүүлж болно.
- 9.2. Олон улс, тив, дэлхий, олимпийн спортын уралдаан тэмцээнд оролцож 1-3 дугаар байранд шалгарсан, спортын болон олон улсын хэмжээний мастерын зэрэгтэй мэргэжлийн боловсролын төвшинд элсэхийг хүссэн тамирчдыг энэ журмын 5.1.3.1 дэх заалтад заасан, мэргэжлийн сургалтад элсэхийг хүссэн тамирчдыг 5.2.3.1 дэх заалтад заасан "Бие бялдар"-ын шалгалтаас чөлөөлж авбал зохих дээд оноогоор тооцно.
- 9.3. Энэ журмын 9.1-9.2 дахь хэсгүүдэд хамаарах хөнгөлөлттэй нөхцөлөөр элсүүлэн суралцуулах асуудлыг салбар комиссын хуралдаанаар хэлэлцэж, төв комиссын даргад танилцуулж, шийдвэрлэнэ.

#### **АРАВ. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТТАЙ ХОЛБООТОЙ ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХ**

- 10.1. Элсэлттэй холбоотой өргөдөл, хүсэлтийг салбар комиссын даргад гаргана.
- 10.2. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2014 оны 07 дугаар сарын 19-ний өдрүүдэд хүлээн авч, шийдвэрлэнэ.

#### **АРВАН НЭГ. ЖУРАМ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

- 11.1. Энэхүү журмыг зөрчигчдөд холбогдох хууль, тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 11.2. Элсэлтийн цахим бүртгэлийн санд бүртгүүлсэн мэдээллийг холбогдох баримт бичгүүдийн эх хувьтай тулгаж, худал мэдүүлсэн тохиолдолд хүчингүйд тооцож, тэнцсэн элсэгчдийн жагсаалтаас хасна.
- 11.3. Элсэгчийн иргэний болон боловсролын үнэмлэх, диплом, бусад баримт бичиг засвартай, хуурамч болох нь тогтоогдсон тохиолдолд элсэгчдийн жагсаалтаас хасаж, уг бичиг баримтыг шалгуулахаар харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлнэ.
- 11.4. Элсэлтийн шалгалтын үйл ажиллагаатай холбоотой учирсан хохирлыг буруутай этгээд бүрэн хариуцна.

**СУРГАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**



**ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН 2014-2015 ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН  
БАКАЛАВРЫН ЗЭРЭГ ОЛГОХ СУРГАЛТЫН ЭЛСЭЛТИЙН  
ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Хууль сахиулахын их сургуулийн /цаашид ХСИС гэх/ бакалаврын зэрэг олгох сургалтад суралцагч элсүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. ХСИС-ийн бакалаврын зэрэг олгох сургалтын элсэлтийн шалгалт зохион байгуулах журам /цаашид БСЭЖ гэх/ нь Монгол Улсын “Боловсролын тухай”, “Дээд боловсролын тухай”, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам” “ХСИС-ийн дотоод журам”, “ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам”, захиалагч агентлаг, байгууллагуудын хүний нөөцийг бэлтгэх, сонгон шалгаруулахтай холбогдох харилцааг зохицуулсан бусад хууль, эрх зүйн актуудад нийцсэн байна.
- 1.3. БСЭЖ-ыг “ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам”-ыг үндэслэн жил бүр шинэчлэн боловсруулж, элсэлтийн шалгалтын төв комисс /цаашид төв комисс гэх/-ын хуралдаанаар хэлэлцүүлэн ХСИС-ийн захирлаар батлуулж, мөрдөнө.
- 1.4. БСЭЖ-аар элсүүлэн суралцуулах мэргэжлийн чиглэл, шалгалтын төрөл, агуулга, дэг, суурь ба хавсралт шалгалтын босго оноог тогтоож, чанарын оноог бодох аргачлал, элсэлт зохион байгуулах хугацаа зэргийг тогтооно.
2. БСЭЖ-д хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно.
  - 2.1. “**Бүртгэлийн сан**” гэж элсэлтийн цахим бүртгэлийн мэдээллийг;
  - 2.2. “**Элсэхийг хүсэгч**” гэж ХСИС-ийн элсэлтийн цахим бүртгэлийн санд бүртгүүлсэн иргэнийг;
  - 2.3. “**Элсэгч**” гэж зохих шаардлага, шалгуурыг хангаж, элсэлтийн хяналтын тоонд багтсан элсэхийг хүсэгчийг;
  - 2.4. “**Алба хаагч**” гэж хууль сахиулах албанд ажиллаж буй иргэнийг;
  - 2.5. “**Элсэлтийн шалгалтын комисс**” гэж элсэлтийн шалгалтыг зохион байгуулахаар томилогдсон бүрэлдэхүүнийг;
  - 2.6. “**Нэмэлт шалгалт**” гэж сургууль өөрийн онцлогт тохируулан авч буй бие бялдар, сэтгэл зүйн сорил, ярилцлагыг;
  - 2.7. “**Шалгалтын хуудас**” гэж элсэхийг хүсэгчийн шалгалтын оноо, үнэлгээний мэдээлэл бүхий хуудсыг;
  - 2.8. “**БЗ-МБС**” гэж бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүссэн, ХСИС-ийн Ахлагчийн сургуульд мэргэжлийн боловсрол эзэмшсэн сонсогчийг;
  - 2.9. “**БЗ-МБАХ**” гэж бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүссэн, мэргэжлийн боловсрол эзэмшсэн алба хаагчийг;
  - 2.10. “**БЗ-ДБАХ**” бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүссэн, дээд боловсролтой гэж алба хаагчийг;
  - 2.11. “**БЗ-5.5**” гэж бакалаврын зэрэг олгох 5.5 жилийн эчнээ сургалтад элсэхийг хүссэн, бүрэн дунд боловсролтой хууль сахиулах байгууллагад ажиллаж буй алба хаагчийг;
  - 2.12. “**БЗ-3**” гэж бакалаврын зэрэг олгох 3 жилийн эчнээ сургалтад элсэхийг хүссэн, дээд боловсролтой хууль сахиулах байгууллагад ажиллаж буй алба хаагчийг тус тус ойлгоно.
3. Элсэлтийн шалгалтын комисс нь /цаашид элсэлтийн комисс гэх/ шалгалтыг хууль ёсны, шударга, ил тод, нээлттэй байх, мэдээллийн хүртээмжтэй, шуурхай байдлыг хангах, зарчмуудыг удирдлага болгон хараат бусаар бие даан зохион байгуулна.
4. Энэхүү журам болон элсэлтийн шалгалттай холбогдох мэдээллийг ХСИС-ийн “[www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn)” болон захиалагч агентлаг, байгууллагуудын цахим хуудсанд байршуулна.

**ХОЁР. СУРАЛЦУУЛАХ МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ, СУРГАЛТЫН ХЭЛБЭР**

- 2.1. ХСИС нь Боловсрол шинжлэх ухааны яамнаас олгосон “Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийн хүрээнд бакалаврын зэрэг олгох сургалтыг явуулна.

2.1.1. Бакалаврын төвшинд мэргэжил олгох сургалтын чиглэл:

Д / д	Суралцах мэргэжил	Шалгалтын чиглэл		Хугацаа	Харьяа сургууль
		Суурь	Хавсралт		
1	Цагдаа-Хууль сахиулах ажил	Нийгмийн тухай мэдлэг /560 оноо/	Математик /400 оноо/	4 жил	Цагдаагийн сургууль
2	Шүүх шинжилгээ-Хууль сахиулах ажил	Математик	Нийгмийн тухай мэдлэг		

		/560 оноо/	/400 оноо/			
3	Хилийн алба	Нийгмийн тухай мэдлэг	Математик /400 оноо/			Хилийн сургууль
4	Шалган нэвтрүүлэх алба- Хууль сахиулах ажил		/560 оноо/			
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл- Хууль сахиулах ажил	Математик /560 оноо/				
6	Онцгой байдал гамшгаас хамгаалах алба					Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль Онцгой байдлын сургууль
<b>Эчнээ сургалт</b>						
1	Цагдаа-Хууль сахиулах ажил	Нийгмийн тухай мэдлэг /500 оноо/	Математик /400 оноо/	Чанарын оноог томъёогоор тооцно.	5.5 жил	Цагдаагийн сургууль
2		Нийгмийн тухай мэдлэг, математикийн шалгалтыг элсэлтийн комисс авна.			3 жил	
3	Хилийн алба	Нийгмийн тухай мэдлэг /500 оноо/	Математик /400 оноо/		5.5 жил	Хилийн сургууль
4		Нийгмийн тухай мэдлэг, математикийн шалгалтыг элсэлтийн комисс авна.			3 жил	
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл- Хууль сахиулах ажил	Нийгмийн тухай мэдлэг /500 оноо/	Гадаад хэл /400 оноо/		5.5 жил	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль
6		Нийгмийн тухай мэдлэг, гадаад хэлний шалгалтыг элсэлтийн комисс авна.			3 жил	

2.1.1.1. Ерөнхий шалгалтын суурь ба хавсралт шалгалтын чанарын оноог дараах томъёогоор бодно:

$$K = \frac{(a * 1,5) + b}{2}$$

a=суурь шалгалтын оноо

b=хавсралт шалгалтын оноо

2.1.1.2. Мэргэжлийн үнэмлэх болон бакалаврын дипломын голч дүнг чанарын оноонд дараах томъёогоор шилжүүлнэ.

$$K = \frac{C * 1000}{4}$$

C= Элсэхийг хүсэгчийн мэргэжлийн үнэмлэх, бакалаврын дипломын голч дүн

1000= Ерөнхий шалгалтын чанарын онооны авбал зохих дээд үнэлгээ

4= Голч дүнгийн авбал зохих дээд үнэлгээ

2.2. ХЗЯ-ны захиалагч агентлагууд нь тухайн жилд бакалаврын төвшний мэргэжил олгох, мэргэшүүлэх сургалтад элсүүлэх мэргэжлийн чиглэл, элсэлтийн хяналтын тооны захиалгыг 2014 оны 04 дүгээр сарын 01-ний дотор ХСИС-д ирүүлнэ.

2.3. ХСИС захиалгат боловсон хүчнийг бэлтгэх эрэлт, хэрэгцээ, шаардлага, боломж, нөхцөлийг судлан ХЗЯ-тай зөвшилцөн элсэлтийн хяналтын тоог тогтоон, БШУЯ-аар батлуулна.

2.4. ХСИС нь бакалаврын зэрэг олгох сургалтыг өдөр, эчнээ хэлбэрээр явуулах ба шаардлага хангасан элсэхийг хүсэгчид экстернат, зайн сургалтыг сонгон суралцах эрхтэй.

#### **ГУРАВ. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧИД ТАВИХ ШААРДЛАГА**

3.1. ХСИС-ийн бакалаврын зэрэг олгох сургалтад элсэхийг хүсэгчид тавих шаардлага нь сургалтын хэлбэр, эзэмшсэн боловсролоос хамааран ялгамжтай байна.

3.1.1. Бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүсэгч нь ХСИС-ийн Ахлагчийн сургуульд мэргэжлийн боловсрол эзэмшсэн сонсогч, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмшин хууль сахиулах албанд ажиллаж буй алба хаагч байна.

3.1.2. Бакалаврын зэрэг олгох 5.5 жилийн эчнээ сургалтад элсэхийг хүсэгч нь бүрэн дунд боловсролтой, 3 жилийн эчнээ сургалтад элсэхийг хүсэгч нь дээд боловсролтой, хууль сахиулах албанд ажиллаж буй алба хаагч байна.

3.2. ХСИС-ийн бакалаврын зэрэг олгох сургалтад элсэхийг хүсэгчид тавих нийтлэг шаардлага:

3.2.1. Нүүрний хэлбэр төрх зөв, ил харагдах 20X05мм-ээс том сорви, шивээсгүй, бие эрхтний гэмтэл согоггүй, эрүүл байх;

3.2.2. Биеийн өндөр: Эрэгтэй 165 см ба түүнээс дээш, эмэгтэй 160 см ба түүнээс дээш байх;

3.2.3. Бакалаврын зэрэг олгох сургалтад элсэхийг хүсэгч нь тухайн сургалтад элсэхийг хүсэгчид тавих насны хязгаарт нийцсэн байх;

3.2.3.1. Бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүсэгч эрэгтэй 17-оос 25 хүртэл, эмэгтэй 17-20 хүртэл настай байх;

3.2.3.2. Бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүссэн дээд боловсролтой алба хаагч болон эчнээ сургалтад элсэхийг хүсэгч алба хаагч

- нь тухайн агентлагийн хүний нөөцийг бэлтгэх, сонгон шалгаруулахтай холбогдох харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн актуудаар тогтоосон насны хязгаарт нийцсэн байх;
- 3.2.4. Бакалаврын зэрэг олгох сургалтад элсэхийг хүсэгч нь холбогдох нэгжийн суралцахыг дэмжсэн зөвшөөрөл авсан байх;
- 3.2.4.1. Шаталсан сургалтын тогтолцооны дагуу ХСИС-ийн Ахлагчийн сургуульд мэргэжлийн боловсрол эзэмшин төгсөж буй сонсогч бакалаврын зэрэг олгох сургалтад элсэх хүсэлтээ арга зүйчдээ бичгээр гаргаж, сургуулийн захирлаас суралцахыг дэмжсэн зөвшөөрөл авсан байх;
- 3.2.4.2. Алба хаагч нь захиалагч агентлагуудын холбогдох нэгжээс суралцахыг дэмжсэн зөвшөөрөл авсан байх;
- 3.3. ХСИС-ийн бакалаврын зэрэг олгох сургалтад элсэхийг хүсэгчид тавих тусгай шаардлага:
- 3.3.1. Бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүсэгчид тавих тусгай шаардлага:
- 3.3.1.1. ХСИС-ийн Ахлагчийн сургуульд мэргэжлийн боловсрол эзэмшсэн сонсогч болон хууль сахиулах албанд ажиллаж буй алба хаагчийн мэргэжлийн үнэмлэхний голч дүн 2.4 буюу түүнээс дээш байх;
- 3.3.1.2. Ерөнхий шалгалтын батламж хүчинтэй байх;
- 3.3.1.3. Ерөнхий шалгалтын суурь ба хавсралт шалгалтын оноо нь энэ журмын 2.1.1 дэх заалтад заасан босго онооны болзлыг хангасан байх;
- 3.3.2. Бакалаврын зэрэг олгох эчнээ сургалтад элсэхийг хүсэгчид тавих тусгай шаардлага:
- 3.3.2.1. Эчнээ хэлбэрийн 5.5 жилийн сургалтад элсэхийг хүсэгч бүрэн дунд боловсролтой, алба хаагч нь энэ журмын 3.3.1.2-3.3.1.3 дахь заалтад заасан шаардлагыг хангасан байх;

#### **ДӨРӨВ. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧИЙГ БҮРТГЭХ**

- 4.1. Бакалаврын зэрэг олгох сургалтад элсэхийг хүсэгч ХСИС-ийн [www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn) хаягаар нэвтрэн орж, элсэлтийн бүртгэлийн санд цахим хэлбэрээр 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийн 18.00 цаг хүртэл зөвхөн нэг мэргэжлийн чиглэлээр, сургалтын хэлбэрээ сонгож бүртгүүлнэ.
- 4.2. Бүртгүүлэхийн өмнө энэ журам болон “ХСИС-ийн элсэлтийн шалгалт зохион байгуулах нийтлэг журам”, бусад нэмэлт мэдээллүүдтэй танилцсан байна.
- 4.3. Бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүсэгч бүртгэлийн сангийн “БЗ-МБС”, “БЗ-МБАХ”, “БЗ-ДБАХ” цэснүүдээс, эчнээ сургалтад элсэхийг хүсэгч “БЗ-5.5”, “БЗ-3” цэснүүдээс тохирохыг сонгон цахим бүртгэлийн програмаас өгөгдөх зааварчилгааны дагуу мэдээллээ оруулан бүртгүүлнэ.
- 4.4. Бүртгүүлсэн элсэхийг хүсэгчид хувийн нууц код олгож, цахим хаягаар нь илгээнэ.

#### **ТАВ. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:**

- 5.1. Элсэлтийн комисс:
- 5.1.1. Бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүссэн “БЗ-МБС”, “БЗ-МБАХ”-ийн мэргэжлийн үнэмлэхний голч дүн энэ журмын 3.3.1.1 дэх заалтад заасан шаардлагыг хангасан эсэхийг тогтооно;
- 5.1.2. Боловсролын үнэлгээний төвөөс ерөнхий шалгалтын оноо зарлагдсаны дараа ерөнхий шалгалтыг 2013, 2014 онд өгсөн, батламж нь хүчинтэй байгаа өдрийн сургалтад элсэхийг хүссэн ХСИС-ийн Ахлагчийн сургуульд мэргэжлийн боловсрол эзэмшсэн сонсогч, Хууль сахиулах албанд ажиллаж буй мэргэжлийн боловсрол эзэмшсэн алба хаагчийн суурь ба хавсралт шалгалтын оноо энэ журмын 2.1.1-т заасан босго онооны болзол хангасан эсэхийг тогтоож, 2.1.1.1-т заасан томъёогоор чанарын оноонд шилжүүлнэ;
- 5.1.3. Бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүсэгчийн энэ журмын 5.1.1 ба 5.1.2 дахь заалтаар тогтоогдсон оноонуудын нийлбэрийг буурах эрэмбээр жагсааж, мэргэжил тус бүрийн хяналтын тоонд багтаан шалгаруулна;
- 5.1.4. Бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтад элсэхийг хүссэн, энэ журмын 3.2.3.2-т заасан шаардлагыг хангасан дээд боловсролтой алба хаагчийг ХСИС-ийн элсэлтийн комиссоос авах энэ журмын 2.1.1-т тодорхойлсон мэргэжлийн чиглэлүүдэд харгалзах шалгалтуудад авсан онооны нийлбэрээр буурах эрэмбээр жагсааж, хяналтын тоонд багтаан шалгаруулна;
- 5.1.5. Бакалаврын зэрэг олгох эчнээ хэлбэрийн 5,5 жилийн сургалтад элсэхийг хүссэн бүрэн дунд боловсролтой алба хаагчдын ерөнхий шалгалтын хүчинтэй батламж дахь суурь ба хавсралт шалгалтын оноо босго онооны болзол хангасан эсэхийг тогтоож, чанарын оноонд 2.1.1.2-т заасан томъёогоор шилжүүлэн онооны буурах эрэмбээр жагсааж, мэргэжил тус бүрийн хяналтын тоонд багтаан шалгаруулна;

- 5.1.5. Бакалаврын зэрэг олгох эчнээ хэлбэрийн 3 жилийн сургалтад элсэхийг хүсэгчдийг ХСИС-ийн элсэлтийн комиссоос авах энэ журмын 2.1.1-т тодорхойлсон мэргэжлийн чиглэлүүдэд харгалзах шалгалтуудад авсан онооны нийлбэрээр буурах эрэмбээр жагсааж, хяналтын тоонд багтаан шалгаруулна;
- 5.1.6. Хяналтын тоонд багтан тэнцсэн бакалаврын зэрэг олгох өдөр, эчнээ хэлбэрийн сургалтад элсэгчдийн нэрс, оноог их сургуулийн байрлал дахь мэдээллийн самбар, ХСИС-ийн "[www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn)" вэб хуудсаар дамжуулан нийтэд зарлах ба цахим хаягаар нь илгээнэ.
- 5.1.7. Бакалаврын зэрэг олгох өдрийн болон эчнээ 3 жилийн сургалтад элсэхийг хүссэн алба хаагчдаас авах нэмэлт шалгалтыг 2014 оны 06 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулна.

#### **ЗУРГАА. ЭЛСЭГЧДИЙГ БҮРТГЭХ**

- 6.1. Ахлагчийн сургуульд мэргэжлийн боловсрол эзэмшсэн, энэ журмын 5.1.3 дахь заалтад заасан шаардлагыг хангасан сонсогчид ХСИС-ийн шаталсан сургалтаар бакалаврын зэрэг олгох сургалтад суралцах эрх үүснэ.
- 6.2. Суралцах эрх үүссэн "БЗ-МБС"-чид 2014 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс 2014 оны 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд 09.00-16.00 цагуудад дараах баримт бичгийг бүрдүүлэн бүртгүүлнэ.
  - 6.2.1. Иргэний үнэмлэх, /эх хувь ба нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт/;
  - 6.2.2. Ерөнхий шалгалтын батламж /эх хувь ба нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/;
  - 6.2.3. Ерөнхий боловсролын гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
  - 6.2.4. Дээд боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;/
  - 6.2.5. ЗХ4 хэмжээний 4 хувь зураг;
  - 6.2.6. Гурван үеийн намтар /өөрийн гараар дэлгэрэнгүй бичсэн байх/;
  - 6.2.7. Ерөнхий боловсролын сургуулийн тодорхойлолт;
  - 6.2.8. Зх4 хэмжээний 4 хувь чээж зураг;
  - 6.2.9. Эрүүл мэндийн үзлэгийн хуудас;
  - 6.2.10. Төрийн албан хаагчийн анкет /маягт 1,2/;
- 6.3. Элсэгч журмаар тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй тохиолдолд суралцахаас сайн дураараа татгалзсанд тооцож хасах бөгөөд тэнцсэн элсэгчдийн нэрсийн жагсаалтын дагуу дараагийн элсэхийг хүсэгчид суралцах эрхийг шилжүүлэн олгоно.

#### **ДОЛОО. ШИЙДВЭР ГАРГАХ**

- 7.1. Салбар комисс бакалаврын зэрэг олгох сургалтын элсэлтийн шалгалтад тэнцэж, хяналтын тоонд багтсан элсэгчдийн нэрсийг их сургуулийн байрлал дахь мэдээллийн самбар, ХСИС-ийн "[www.leu.gov.mn](http://www.leu.gov.mn)" вэб хуудсаар дамжуулан нийтэд зарлах ба цахим хаягаар нь илгээнэ.
- 7.2. Элсэлтийн төв комисс бакалаврын зэрэг олгох сургалтад тэнцсэн элсэгчдийн нэрс, оноог ХСИС-ийн захиралд танилцуулна.
- 7.3. ХСИС-ийн захирлын тушаалаар бакалаврын зэрэг олгох сургалтын элсэлтийн шалгалтад тэнцсэн элсэгчийн суралцах эрхийг баталгаажуулна.
- 7.4. Бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтын элсэлтийн шалгалтад тэнцсэн мэргэжлийн болон бакалаврын боловсролтой алба хаагчийг харьяа агентлагийн холбогдох нэгж албанаас чөлөөлж, суралцах нөхцөлийг хангана.

#### **НАЙМ. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧДЭД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ**

- 8.1. Хууль сахиулах албан үүрэг гүйцэтгэх явцдаа онцгой гавьяа байгуулсан, тухайн агентлаг, байгууллагын ажил мэргэжлийн болон хөдөлмөрийн аваргаар шалгарсан, спортын өндөр амжилт гаргасан алба хаагчийг харьяа агентлаг, байгууллагын саналыг үндэслэн хөнгөлөлттэй нөхцөлөөр элсүүлэн суралцуулж болно.
- 8.2. Суурь ба хавсралт шалгалт өгсөн хичээлээр сүүлийн нэг жилд олон улсын болон улсын олимпиад, уралдаанд шагналт байранд шалгарсан элсэхийг хүсэгчид хөнгөлөлт үзүүлж болно.
- 8.3. Энэ журмын 8.1 дэх хэсэгт заасан хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцах элсэгчийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноо нь авбал зохих босго онооны 70 хувь буюу тухайн жилийн БШУЯ-аас тогтоосон босго оноотой дүйцэж байна.
- 8.4. Энэ журмын 8.1-8.2 дахь хэсгүүдэд хамаарах хөнгөлөлттэй нөхцөлөөр элсүүлэн суралцуулах асуудлыг салбар комиссын хуралдаанаар хэлэлцэж, төв комиссын даргад танилцуулж, шийдвэрлэнэ.

#### **ЕС. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТТАЙ ХОЛБООТОЙ ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХ**

- 10.1. Элсэлттэй холбоотой өргөдөл, гомдол, хүсэлтийг салбар комиссын даргад гаргана.
- 10.2. Иргэнээс гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2014 оны 07 дугаар сарын 19-ний өдрүүдэд хүлээн авч, шийдвэрлэнэ.

#### **АРАВ. ЖУРАМ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

- 10.1 Энэхүү журмыг зөрчигчид холбогдох хууль, тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

- 10.2 Элсэлтийн цахим бүртгэлийн санд бүртгүүлсэн мэдээллийг холбогдох баримт бичгүүдийн эх хувьтай тулгаж, худал мэдүүлсэн тохиолдолд хүчингүйд тооцож, тэнцсэн элсэгчдийн жагсаалтаас хасна.
- 10.3 Элсэгчийн иргэний болон боловсролын үнэмлэх, диплом, бусад баримт бичиг засвартай, хуурамч болох нь тогтоогдсон тохиолдолд элсэгчдийн жагсаалтаас хасаж, уг бичиг, баримтыг шалгуулахаар харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлнэ.
- 10.4 Элсэлтийн шалгалтын үйл ажиллагаатай холбоотой учирсан хохирлыг буруутай этгээд бүрэн хариуцна.

#### СУРГАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР